

LEGAL NEWSLETTER

Second Quarter 2026

№63

AKP Law Firm

Бид 2026 оны 5 дугаар сард батлагдсан онцлох хууль, тогтоол, шийдвэрүүдийг танилцуулж байна.

I. **ӨРГӨН МЭДҮҮЛСЭН БОЛОН ХЭЛЭЛЦЭГДСЭН ХУУЛИЙН ТӨСӨЛ:**

1.1 Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл

Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн уг хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 05 дугаар сарын 21-нд явуулав. Хуулийн төсөл батлагдсанаар дотоодын газрын тосны хэрэглээний 55 хувийг хангах чадвартай газрын тос боловсруулах үйлдвэр барих, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг гадаад зээлийн эх үүсвэрээр барих зэрэг дэд бүтцийн стратегийн томоохон төслүүд хэрэгжих юм. Одоогоор нийт 20.9 их наяд төгрөгийн зөвшилцсөн дүнтэй 74 гадаад зээлийн төсөл хэрэгжиж байгаагаас 34 хувийг ашигласан байна.

1.2 Монгол улсын их хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

УИХ-ын нийт 12 гишүүн 2026 оны 05 дугаар сарын 13-нд өргөн мэдүүлсэн уг хуулийн төсөл нь гишүүдийн хуралдаанд оролцох, санал хураалтад оролцоогүй тохиолдолд хариуцлага тооцох зохицуулалтыг нэмэх зорилготой. Тодруулбал, нэг сарын хугацаанд санал хураалтын 50-иас дээш хувьд оролцоогүй гишүүний цалин, төсвийн санхүүжилтийг хасах, ээлжит чуулганд 5 ба түүнээс дээш удаа хүндэтгэх шалтгаангүйгээр ирээгүй бол хариуцлага тооцохоор тусгажээ.

1.3 Ажил, хөдөлмөр эрхлэгчдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй орчныг бүрдүүлэх тухай хуулийн төсөл

2026 оны 05 дугаар сарын 29-нд Засгийн газраас уг хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барив. Уг хуулийн төсөл ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг сайжруулах, ажил олгогчдын хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн.

II. **УЛСЫН ИХ ХУРАЛ: ОНЦЛОХ ТОГТООЛ**

2.1 Татварын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэхийг дэмжив

2026 оны 05 дугаар сарын 22-нд нэгдсэн хуралдаанаар татварын хуулийн багц нэмэлт, өөрчлөлтийн анхны хэлэлцүүлгийг эхлүүлэхийг дэмжив. Эдийн засгийн чөлөөлөлтийн бодлогын хүрээнд гадаад хөрөнгө оруулагч, дотоодын үйлдвэрлэгч нарт эрх зүйн орчны тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн нэмэлт, өөрчлөлтүүд болохыг Засгийн газар мэдэгджээ.

2.2 Эрүүгийн хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг УИХ хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн Худал мэдээлэл тараах гэмт хэрэгтэй холбоотой заалтыг хүчингүй болсонд тооцохоор хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2026 оны 05 дугаар сарын 21-нд явуулав. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаатай шууд холбоотой энэ заалтын хүчингүй болох нь эрх зүйн чухал өөрчлөлт болно.

III. **ЗАСГИЙН ГАЗРЫН ОНЦЛОХ ТОГТООЛ**

2026 оны 4, 5 дугаар сард нийт 64 Засгийн газрын тогтоол батлагдсан ба тэдгээрээс дараах тогтоолуудыг онцолж байна.

3.1 Тэтгэвэр тогтоолгосон иргэдэд мөнгөн урамшуулал олгохгүй болох тухай

Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 210 дугаар тогтоолоор "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-д өөрчлөлт оруулав.

Уг өөрчлөлтөөр өндөр насны болон цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн төрийн захиргааны байгууллагад төрийн байгууллагад хоёр дахь удаа ажиллуулахад нэмэлт урамшуулал олгохоо зогсоосон бөгөөд төрийн албаны зардлыг хэмнэх, залуу боловсон хүчнийг дэмжих бодлоготой уялдсан шийдвэр гэж үзэж болно.

3.2 Эдийн засгийн эрх чөлөөний бодлого — "чөлөөлөлтийн 12 шийдвэр"

Ерөнхий сайд Н.Учралын удирдлагатай Засгийн газар ажилд орсны эхний сард "Чөлөөлье" бодлогын хүрээнд 12 шийдвэр баталж, эдийн засгийн эрх чөлөөний бодлогын эхлэлийг тавив.

Онцлох арга хэмжээнүүдэд: Татварын өртэй 12,153 компанийн битүүмжлэгдсэн дансыг нээсэн, 2026 онд эрүүл мэнд болон байгаль орчны хяналтаас бусад 7,300 гаруй хяналт шалгалтыг цуцалсан зэрэг орсон.

3.3 Ашигт малтмал хайх талбайн солбицол батлах, эрх олгох тухай

Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 193 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн Сайхан, Орхон сумын нутаг дэвсгэрт байрлах ашигт малтмал хайх талбайн солбицлыг баталж, уг талбайд ашигт малтмал хайх эрхийг "Эрдэнэс Монгол" ХХК-д олгохоор шийдвэрлэв.

3.4 Түлш, эрчим хүчний хараат байдлыг бууруулах тухай

Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 160 дугаар тогтоолоор Монгол Улсын түлш, эрчим хүчний хараат байдлыг бууруулах, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх, ногоон хөгжлийн бодлогыг эрчимжүүлэх чиглэлээр цогц арга хэмжээ хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

IV. ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ТОЙМ, ХУРААНГУЙ

4.1 Баригдаж дуусаагүй барилгад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулахгүй

Улсын дээд шүүхийн 2026 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн №001 дугаартай шүүхийн

шийдвэрээр баригдаж дуусаагүй, ашиглалтад ороогүй барилгад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах хууль зүйн үндэслэлгүй гэж дүгнэв.

Хэрэгт татварын байгууллага 73%-ийн гүйцэтгэлтэй, баригдаж дуусаагүй барилгад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулсан бөгөөд шүүхээс:

- Татвар ногдуулах үндэслэл хуульд тодорхой заагдсан байх ёстой;
- Дуусаагүй барилгад татвар ногдуулах хууль тогтоогчийн хүсэл зориг Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд тусгагдаагүй;
- Өмчлөх эрх улсын бүртгэлд бүртгэгдсэн нь дангаараа үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үндэслэл болохгүй;
- Барилга 100%-ийн гүйцэтгэлтэй болж, ашиглалтад орсон буюу зориулалтын дагуу ашиглах боломжтой болсон үеэс татвар ногдох нөхцөл бүрдэнэ гэж тайлбарлан татварын нэхэмжлэхийг илт хууль бус гэж үзсэн.

Практик ач холбогдол: Баригдаж дуусаагүй, ашиглалтад ороогүй барилгад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах эсэх асуудлаар татварын хууль тогтоомжийг зорилго, агуулгаар нь тайлбарласан чухал жишиг шийдвэр боллоо.

4.2 Шинээр эрх олгосон хэм хэмжээг буцаан хэрэглэх тухай

Улсын дээд шүүхийн 2026.04.08-ны өдрийн тогтоолоор насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн шүүгдэгчээс хохирогчид гаргуулах сэтгэл санааны хохирлыг гаргуулсан хэргийг хэлэлцэв.

Анхан болон давж заалдах шатны шүүхүүд гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан сэтгэцэд учирсан хор уршгийн 14,000,000 төгрөгөөр тооцож шүүгдэгчээс гаргуулсан боловч Дээд шүүхээс сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөрийн хэсгийг хүчингүй болгожээ.

Дээд шүүхийн үзсэнээр, гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх эрх нь 2022 онд хуульчлагдаж, 2023 оны 7 дугаар сарын 01-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн шинэ материаллаг эрх зүйн зохицуулалт байна. Иймд уг зохицуулалтыг өмнөх хугацаанд үүссэн эрх зүйн харилцаанд буцаан хэрэглэх боломжгүй гэж дүгнэжээ.

ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Олимпийн гудамж, Centrum Office, 3 давхар,
301/а
Web: www.akp.mn
E-mail: contact@akp.mn
Tel: 7704-1414, 8013-0414